



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/723

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Чингисийн өргөн чөлөө, Их сургуулийн гудамж (Самбуугийн гудамжнаас Энх тайваны өргөн чөлөө хүртэл), Хуульчдын гудамж, Ерөнхий сайд А.Амарын гудамж, П.Гэндэнгийн гудамжнуудад 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 08:00-20:00 цагийн хооронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласугай.

2.Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан хугацаанд нийтийн тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний чиглэлд зохицуулалт хийхийг Нийслэлийн Нийтийн тээврийн газар (Ч.Сайханбаяр)-т, хөдөлгөөний аюулгүй байдал, хэв журмыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал), Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар (С.Жавхлантбаатар)-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т, хөдөлгөөнийг хязгаарласан гудамж, зам, талбайд байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчлан, олон нийтийг хамарсан уралдаан, тэмцээн, худалдаа, үйлчилгээ зохион байгуулахыг дүүрэг, агентлаг, харьяа газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөөд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР